

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны ... сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

### **Норматив тогтоох тухай**

“Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн 6.4 дэх заалт болон Засгийн газрын 2017 оны 46 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог нийслэл хот, аймгийн төвийн суманд 4000 хүртэл хүн ам тутамд, бусад суманд 2000 хүртэл хүн ам тутамд тус тус 1 байхаар тогтоосугай.

2. Согтууруулах ундааны төрлөөс хамааран согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх худалдаа, үйлчилгээний газрын төрлийг хавсралтаар баталсугай.

3. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, амралтын газрын дэргэдэх худалдаа, үйлчилгээний газраас бусад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгт зөвшөөрөл олгоход энэхүү нормативыг дагаж мөрдсүгэй.

4. Энэхүү нормативт нийцүүлэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлж байхыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110, 2008 оны 05 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**Согтууруулах ундааны төрлөөс хамааран согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх худалдаа, үйлчилгээний газрын төрөл**

№	Согтууруулах ундааны төрөл	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх газрын төрөл	
		Худалдааны газар	Үйлчилгээний газар
1	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа*	<ul style="list-style-type: none"> <li>• хүнсний дэлгүүр</li> <li>• минимаркет</li> <li>• супермаркет</li> <li>• хайпермаркет</li> <li>• их дэлгүүр</li> <li>• агуулах дэлгүүр</li> <li>• бөөний төв</li> <li>• зах, худалдааны төвийн төрөлжсөн цэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• кафе</li> <li>• ресторан</li> <li>• баар</li> </ul>
2	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа**	<ul style="list-style-type: none"> <li>• супермаркет</li> <li>• хайпермаркет</li> <li>• их дэлгүүр</li> <li>• агуулах дэлгүүр</li> <li>• бөөний төв</li> <li>• зах, худалдааны төвийн төрөлжсөн цэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ресторан</li> <li>• баар</li> </ul>

Тайлбар:       \*- 18 хувь хүртэл хүнсний этилийн спирт агуулсан согтууруулах ундаа  
                  \*\* - 18 хувиас дээш хүнсний этилийн спирт агуулсан согтууруулах ундаа